



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 4/157

Мандалговь

Г "Mongolian TRY-2018" нөлөөллийн  
арга хэмжээнд дэмжлэг  
үзүүлэх тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 9 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Түгээмэл хөгжил" ТББ болон Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулж буй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг нийгэмшүүлэх, оролцоог хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд олон нийт ажил олгогчдыг уриалах зорилгоор "Mongolian TRY-2018" нөлөөллийн арга хэмжээг Улаанбаатар-Төв- Дундговь-Өмнөговь чиглэлд зохион байгуулж байгаатай холбогдуулан дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. "Mongolian TRY-2018" нөлөөллийн арга хэмжээнд оролцогчдод зориулсан дэмжлэгийг хавсралтаар баталсугай.

Гурав. Оролцогчдын хоол болон түлш шатахууны зардалд зориулагдах 455150 (Дөрвөн зуун тавин таван мянга нэг зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200758

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн /2018/ тоот захирамжийн хавсралт



**ХООЛНЫ МАТЕРИАЛЫН ТӨСӨВ**

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Байцаа	12	2000	24000
2	Боов	3	3000	9000
3	Будаа	7	3000	21000
4	Гоймон	4	2500	10000
5	Гурил	10	1800	18000
6	Давс	1	1500	1500
7	Дашида	1	2000	2000
8	Дунаский салат	3	4800	14400
9	Исгэгч	4	250	1000
10	Их тайга	1	2500	2500
11	Крахмал	2	2000	4000
12	Лууван	2	2400	4800
13	Манжин	2	2400	4800
14	Масло	0.5	5000	2500
15	Мах	28	6500	182000
16	Сахар	2	2000	4000
17	Сонгино	3	2500	7500
18	Сүү	17	2800	47600
19	Талх	3	1100	3300
20	Төмс	14	1400	19600
21	Ургамалын тос	1	3500	3500
22	Чөснок	1	2000	2000
23	Чинжүү	1	6000	6000
24	Шар будаа	2	2500	5000
25	Бензин /дизель/	26.3	2100	55150
	<b>Нийт</b>			<b>455150</b>